210402	Тээвэр, шатахуун	36,451,600.00	33,803,426.00	30,741,600.00	30,461,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,297,600.00	5,826,160.00	8,497,600.00	7,769,740.00
210404	Ном, хэвлэл	1,560,400.00	1,046,300.00	1,858,600.00	1,721,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,222,500.00	1,191,377.00	8,467,300.00	8,341,227.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,462,200.00	10,462,200.00	13,673,500.00	13,673,500.00
2105	Нормативт зардал	84,379,200.00	53,909,849.00	103,595,400.00	101,724,700.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	18,914,300.00	17,079,339.00	23,199,700.00	22,929,710.00
210502	Хоол, хүнс	61,790,700.00	33,164,810.00	75,937,800.00	74,337,490.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,674,200.00	3,665,700.00	4,457,900.00	4,457,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,919,700.00	17,919,200.00	19,466,900.00	19,466,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,092,800.00	13,092,800.00	4,615,600.00	4,615,600.00
210604	Урсгал засвар	4,826,900.00	4,826,400.00	14,851,300.00	14,850,800.00
2107	Томилолт, зочны зардал	5,592,300.00	2,869,600.00	7,219,400.00	5,368,000.00
210702	Дотоод албан томилолт	5,592,300.00	2,869,600.00	7,219,400.00	5,368,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,303,200.00	15,154,223.00	5,199,600.00	4,691,550.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,686,600.00	12,607,390.00	2,302,500.00	2,160,309.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,340,000.00	2,148,000.00	1,196,300.00	878,300.00
210803	Даатгалын үйлчилгээ	594,700.00	59,200.00	790,000.00	790,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	478,900.00	238,535.00	409,100.00	399,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	78,000.00	-	85,900.00	48,141.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	-	132,000.00	132,000.00
210807	Газрын төлбөр	125,000.00	101,098.00	283,800.00	283,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	44,406,200.00	37,200,750.00	71,202,400.00	67,883,250.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	40,853,800.00	33,653,250.00	65,634,400.00	62,321,150.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,552,400.00	3,547,500.00	5,568,000.00	5,562,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,410,400.00	12,196,250.00	31,844,100.00	31,843,300.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,410,400.00	12,196,250.00	31,844,100.00	31,843,300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	13,670,400.00	10,052,250.00	29,922,800.00	29,922,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,740,000.00	2,144,000.00	1,921,300.00	1,920,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	72,227,700.00	71,365,400.00	91,891,000.00	87,865,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	72,227,700.00	71,365,400.00	91,891,000.00	87,865,000.00
223001	Бусад хөрөнгө	72,227,700.00	71,365,400.00	91,891,000.00	87,865,000.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	151,000,000.00	152,523,479.00	103,550,000.00	100,639,500.00
230001	Эргэж төлөгдөх зээл	151,000,000.00	152,523,479.00	103,550,000.00	100,639,500.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,271,739,900.00	2,209,920,410.00	2,261,295,700.00	2,264,132,742.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,253,010,700.00	1,239,884,290.00	1,263,068,200.00	1,263,068,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,253,010,700.00	1,239,884,290.00	1,263,068,200.00	1,263,068,200.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	816,163,900.00	834,763,500.00	856,882,200.00	852,360,500.00
132001	Орон нутгийн төсвөөс	743,936,200.00	762,535,800.00	784,991,200.00	760,469,500.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	72,227,700.00	72,227,700.00	91,891,000.00	91,891,000.00

Зүүнбаян-Улаан сумын Төрийн сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	22,195,300.00	41,064,440.00	22,195,300.00	40,724,710.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	41,114,400.00	41,064,440.00	41,114,400.00	40,724,710.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	180,370,000.00	94,208,180.00	119,150,000.00	107,979,332.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	50,000,000.00	84,015,894.00	65,550,000.00	86,794,332.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,600,000.00	10,192,286.00	10,600,000.00	21,185,000.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	119,770,000.00		43,000,000.00	
4	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эхний үлдэгдэл		108,001,512.88		45,572,459.88
5	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		45,572,459.88		41,936,384.88

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	108,277,515.00	187,015,437.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	78,277,515.00	171,480,437.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	78,277,515.00	142,938,936.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	27,497,165.00
210102	Нэмэгдэл		5,636,265.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		17,600,000.00
210105	Гэрээт ажлын хөлс		4,260,900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	1,213,723.15
210201	Тэтгэврийн даатгал		988,273.36
210202	Тэтгэмжийн даатгал		56,362.57
210203	ҮОМШӨ-ний даатгал		45,090.07
210204	Ажилгүйдлийн даатгал		11,272.51
210205	Эрүүл мэндийн даатгал		112,724.64
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	347,211.00
210303	Цэвэр, бохир ус	-	347,211.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,703,360.00	2,787,571.00
210401	Бичиг хэрэг	-	203,471.00
210402	Тээвэр, шатахуун	4,042,780.00	2,019,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,660,580.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		564,400.00
2105	Нормативт зардал	3,999,985.00	59,998,175.85
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,999,985.00	56,372,413.85
210502	Хоол, хүнс	-	3,625,762.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,280,000.00	9,700,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	17,280,000.00	-
210604	Урсгал засвар	-	9,700,000.00
2107	Томилолт, зочны зардал	690,000.00	324,000.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	690,000.00	324,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	33,204,170.00	28,500,668.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	33,204,170.00	28,500,668.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,400,000.00	12,570,422.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,400,000.00	12,570,422.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	28,541,501.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	28,000,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		28,000,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	13,000,015.00	541,501.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	13,000,000.00	541,501.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	15.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	30,000,000.00	15,535,000.00

Зүүнбаян-Улаан сумын Төрийн сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2200	Дотоод эх үүсвэрээр	30,000,000.00	15,535,000.00
222001	Тоног төхөөрөмж		2,535,000.00
223001	Бусад хөрөнгө	30,000,000.00	13,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	121,277,530.00	187,015,437.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	121,277,530.00	187,015,437.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	71,604,100.00	57,718,593.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	46,391,630.00	125,485,844.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,281,800.00	3,811,000.00

3.Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Зүүнбаян-Улаан сумын Төрийн сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитыг 2022.03.14-өөс 2022.03.23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2022.03.23-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Р.Энхзул хариуцаж хэрэгжүүлэв.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газарт 2022.03.14-ний өдрийн 1/30 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

Сумын төрийн сангийн нэгтгэсэн тайланд 6 төсөвт байгууллага, 3 сан, 1 ерөнхий орлогын данс, нийт 10 тайлан нэгтгэгджээ.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.”Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн удирдлага дор төсвийн шууд захирагчийг харьяалах эрх бүхий төсвийн төвлөрүүлэн захирагчтай байж болно.” гэж заасан.

Мөн хуулийн 36.1.”Төрийн сангийн тогтолцоо нь төв төрийн сан, аймаг, нийслэлийн төрийн сан, сум, дүүргийн төрийн сан, төрийн захиргааны төв байгууллагын төрийн сангийн нэгж, төсвийн нягтлан бодогч /цаашид “төрийн сан” гэх/-оос бүрдэнэ.

36.2.Төв төрийн сан нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сан нь тухайн шатны Засаг даргын Тамгын газрын дэргэд байна.

36.3.Сум, дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа төсвийн байгууллагын үйл ажиллагааны чиглэл болон төсвийн хэмжээг нь харгалзан төрөлжүүлж, тэдгээрт хамаарах төсвийн байгууллагуудад нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх нэгдсэн алба байгуулж болно” гэсэн заалтуудаар зохицуулагдаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил

гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Зүүнбаян-Улаан сумын Төрийн сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Зүүнбаян-Улаан сумын Төрийн сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 3401.8 сая төгрөгөөс 1 хувиар буюу 34.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 27.2 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 89.2 сая төгрөгөөр өссөн байна.

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	162.1	251.3	89.2
31211	Төрийн сангийн харилцах	162.1	251.3	89.2

Дараах байгууллагуудын данс мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарсан байна.

- Эрүүл мэндийн төв – 0.6 сая төгрөг

- Сум хөгжүүлэх сан – 25.6 сая төгрөг
- Эрсдэлээс хамгаалах сан – 10.8 сая төгрөг
- Орон нутгийн хөгжлийн сан – 4.9 сая төгрөг
- Орон нутгийн ерөнхий орлого – 209.4 сая төгрөг

3.5.2 Авлага

Дансны код	Балансын үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Зөрүү
33	АВЛАГА	216.2	294.0	77.8
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	0.2	0.2
33300	Татаас, санхүүжилтийн авлага	5.2	71.0	65.8
33400	Зээлийн хүүгийн авлага	4.9	5.8	0.9
33510	Байгууллагаас авах авлага	8.6	-	(8.6)
33520	Хувь хүмүүсээс авах авлага	197.5	217.0	19.5

Тайлант онд авлага 77.8 сая төгрөгөөр өссөн байна. Нийт авлагын 84.6 хувийг татаас санхүүжилтийн авлага эзэлж байгаа бөгөөд ЭМТ-ийн ЭМД-аас авах авлага байна.

3.5.3 Бараа материал

Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 56.9 сая төгрөгөөр өссөн байна.

Дансны код	Балансын үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Зөрүү
35	БАРАА МАТЕРИАЛ	85.9	142.8	56.9
351	Түүхий эд материал	33.6	61.1	27.5
354	Хангамжийн материал	52.3	81.7	29.4

Тайлант онд бараа материал ЗДТГ 10.0 сая төгрөг, ИТХ 0.8 сая төгрөг, ЭМТөв 44.7 сая төгрөг, ЕБС 2.9 сая төгрөг, Соёлын төв 0.1 сая төгрөг төгрөгөөр тус тус өсөж, Цэцэрлэг 1.6 сая төгрөгөөр буурсан байна.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 318.0 сая төгрөгөөр өссөн байна.

№	Үзүүлэлт	Хөрөнгийн дүн
1	Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл	5,398.9
2	Нэмэгдсэн	532.8
201	Худалдан авсан	20.2
203	Шилжүүлэн авсан	8.6
205	Бусад	481.8
206	Дахин үнэлгээний нэмэгдэл	22.2
3	Хасагдсан	214.8
302	Акталсан	103.7
303	Шилжүүлсэн	4.8
305	Бусад	16.3
306	Дахин үнэлгээний хорогдол	90.0
4	Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,716.9

Зүүнбаян-Улаан сумын Төрийн сангийн үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн нэгтгэлээр 532.8 сая төгрөгийн хөрөнгө шинээр бүртгэлд тусгаснаас 20.2 сая төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 22.2 сая төгрөг дахин үнэлгээний нэмэгдэл, 8.6 сая төгрөгийн хөрөнгө шилжүүлэн ирсэн, 481.8 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч бүртгэлд тусгажээ. Харин 103.7 сая төгрөгийн хөрөнгийг акталж, 4.8 сая төгрөгийн хөрөнгийг

шилжүүлэн, 90.0 сая төгрөгийн хөрөнгийг дахин үнэлгээний хорогдол, 16.3 сая төгрөгийн хөрөнгийг тус тус данснаас хассан байна.

3.5.5 Өр төлбөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Зөрүү
413	Өглөг	5.2	71.9	66.7
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	52.8	52.8
41361	Байгууллагад төлөх өглөг	5.2	18.5	13.3
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	0.6	0.6

Тайлант онд өр төлбөр 66.7 сая төгрөгөөр өссөн. Нийт өр төлбөрийн 98.6 хувийг ЭМТөвийн өр эзэлж байгаа бөгөөд энэ нь ажилчдын цалинд 52.7 сая төгрөг, байгууллагад 13.1 сая төгрөгөөр эм болон бараа материалын өр нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

3.6.1 Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Сумын ИТХ-ын 2021 оны 5/02 тоот тогтоолоор орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын болон татварын бус орлогыг 73.1 сая төгрөгөөр баталжээ. Гүйцэтгэлээр 154.7 сая төгрөгийн орлого төвлөрч, орлогын төлөвлөгөө 81.6 сая төгрөг буюу 211.2 хувиар давуулан биелүүлсэн байна.

№	Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Үйл ажиллагааны орлого	18.0	12.3	(5.7)	68.3%
2	Хөрөнгийн албан татвар / хадгаламж	14.6	17.9	3.3	122.6%
3	Улсын тэмдэгтийн хураамж	1.9	1.6	(0.3)	84.2%
4	Хог хаягдлын хураамж	7.6	7.7	0.1	101.3%
5	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	0.3	1.0	0.7	333.3%
6	Газрын төлбөр	3.0	3.6	0.6	120.0%
7	Ойн нөөц ашигласны төлбөр	10.5	10.6	0.1	101.0%
8	Хөрөнгө борлуулсаны орлого	0.4	0.1	(0.3)	15.0%
9	Бууны албан татвар	3.5	2.9	(0.6)	82.9%
10	Малын албан татвар	-	91.5	91.5	
11	Хүү, торгуулийн орлого	13.3	5.5	(7.8)	41.4%
Нийт орлогын дүн		73.1	154.7	81.6	211.6%

3.6.2 Орон нутгийн төлөвлөлт, гүйцэтгэл

2021 онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагааг санхүүжүүлэхээр 2280.2 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1263.1 сая төгрөгийг улсын төсвөөс, 856.9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 41.1 сая төгрөгийг нийгмийн даатгалын сан, 119.1 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1235.1 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 833.9 сая төгрөг, нийгмийн даатгалын сангаас 40.7 сая төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагаа болон санхүүгийн дэмжлэгээр 108.0 сая төгрөг, нийт 2217.7 сая төгрөгийн санхүүжилт, болон орлогын эх үүсвэр бүрдүүлжээ.

Үүнээс бараа үйлчилгээний зардалд 2000.2 сая төгрөг, хөрөнгийн зардалд 87.9 сая төгрөг, эргэн төлөгдөх зээлд 100.6 сая төгрөг, урсгал шилжүүлэгт 31.8 сая төгрөгийг зарцуулж нийт гүйцэтгэл 2220.5 сая төгрөг байна.

Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн дансаар сумын хэмжээнд 187.0 сая төгрөгийн санхүүжилт авч бараа үйлчилгээний зардалд 142.9 сая төгрөг, урсгал шилжүүлэгт 28.5 сая төгрөг, хөрөнгийн зардалд 15.6 сая төгрөгийг зарцуулжээ.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Асуудлын онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэгт онцлон дурдах зүйл байхгүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 2 чиглэлээр аудитын 2 горим сорил гүйцэтгэсэн.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Зүүнбаян-Улаан сумын Төрийн сан нь 2021 онд 154 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулахаас 139 мэдээллийг ил тод хугацаанд нь, 15 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар алдаа, зөрчил илрээгүй.

3.11 Аудитын үр өгөөжийн тооцоолол

Төлөвлөлтийн шатанд 2.0 сая төгрөгийн үр өгөөжийг төлөвлөсөн. Аудитаар тооцож бүртгэсэн үр өгөөж байхгүй.

4. Аудитын илрүүлэлт

Зүүнбаян-Улаан сумын Төрийн сангийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй.

4.1 Харьяа байгууллагуудад илэрсэн зөрчлийн талаар

Аудитад хамрагдсан 8 байгууллагын 5 байгууллагад дүгнэлт гаргаж, / ЗДТГ, ИТХ, ЕБС, Соёлын төв, Цэцэрлэг/ 3 байгууллагыг түүвэрт хамруулсан /ЭМТ, ОНХСан, СХСан/

Харьяа байгууллагуудын зөрчлийн нэгтгэлээр 99.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч 16.9 сая төгрөгийн алдааг залруулж, 82.9 сая төгрөгийн 8 албан шаардлага, 1 зөвлөмжийг хүргүүлсэн.

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой нийт **1.4** сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн. Үүнд:

ЗДТГ- Байгууллагын үйл ажиллагааны үндсэн данснаас 1.0 сая төгрөгийн төсвийн хөрөнгийг уралдаан тэмцээний зардлыг шилжүүлсэн.

Цэцэрлэг- Хөдөлмөр хамгааллын 0.3 сая төгрөгийн хувцас хийсэн.

Соёлын төв- Албаны болон ажлын нийт 0.1 сая төгрөгийн дүрэмт хувцас шинээр худалдан авсан

- Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой **16.9** сая төгрөгийн алдааг залруулсан.

ЗДТГ- Мөнгөн гүйлгээний тайлангийн уялдаа 6.3 сая төгрөгөөр зөрсөн.

ИТХ- Шинээр худалдан авсан 0.5 сая төгрөгийн камерыг үндсэн хөрөнгөд бүртгээгүй, Шинээр худалдан авсан 0.8 сая төгрөгийг самбарыг шууд зарлагадсан, Цалингийн урьдчилгаа болох 0.1 сая төгрөгийг авлагат тусгаагүй

Соёлын төв- Урсгал засварын 2.5 сая төгрөгийн материалыг үндсэн хөрөнгөд бүртгэсэн

Цэцэрлэг- Үндсэн хөрөнгийн тооллогын бүртгэл санхүүгийн тайлангийн хөрөнгийн тодруулга тайлантай 6.7 сая төгрөгийн зөрүүтэй тайлагнасан.

- Дотоод хяналт хариуцлагатай холбоотой **6.2** сая төгрөгийн зөрчил илэрсэн.

ИТХ- Бараа материалын 6.2 сая төгрөгийн орлого, зарлагыг бөөн дүнгээр бүртгэснээр хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт хэрэгжихгүй байх эрсдэлтэй байна.

ОНХС- Ажил гүйцэтгэгч талтай шууд гэрээ байгуулахдаа ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргаагүй байна.

- Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой **2.5** сая төгрөгийн дараах зөрчил илэрсэн.

ЕБС- Тайлант хугацаанд ажлын дүрэмт хувцас авахад 0,4 сая төгрөг, албан томилолтод 0.3 сая төгрөг, спортын уралдаан тэмцээнд 0.3 сая төгрөг, нийтдээ 1,0 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна. Дотуур байрны хүүхдийн хоолны зардлын нормативыг 0,7 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан, мөн 1-6-р ангийн сурагчдын үдийн хоолны зардлын нормативыг 2021 оны 1-6 сард 1,2 сая төгрөгөөр хэтрүүлсэн ба 2021

Зүүнбаян-Улаан сумын Төрийн сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

оны 9-12 сард 0,4 сая төгрөгөөр хэмнэсэн ба нийт дүнгээрээ 0,8 сая төгрөгөөр хэтрүүлсэн.

- Нийцлийн аудитаар **72.8** сая төгрөгийн зөрчил илэрсэн.

ЗДТГ- Аудитын баримтын тулгалтаар байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар орсон 5 төрлийн 45.3 сая төгрөгийн санхүүжилт, 3 төрлийн 25.4 сая төгрөгийн зардлыг шилэн дансны сайтад мэдээлээгүй.

Соёлын төв - Шилэн дансны сайтад нийт 2.1 сая төгрөгийн хөрөнгө зарцуулах болон тэтгэмж олгох тухай 13 тушаал шийдвэрийг мэдээлээгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

(сая төгрөгөөр)

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Зүүнбаян-Улаан сумын Төрийн сан	0	0	0	00	0	0	0	0	0	0

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН: АУДИТОР

О.БАТЖАРГАЛ

Д.ГАНСҮХ

Р.ЭНХЗУЛ

2022 ОНЫ 03 ДУГААР САРЫН 25-НЫ ӨДӨР